



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 сарын 07 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

АЛДАР ЦОЛТОН АХМАД НАСТАНД ТӨРӨӨС НЭМЭГДЭЛ, ХӨНГӨЛӨЛТ ОЛГОХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг:

“8.2. Энэ хуулийн 7.1-д заасан баримт бичгийг үндэслэн Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд харьяалах ахмад настанд олгох нэмэгдлийг сар бүр, нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь хөнгөлөлтийг тухай бүр ахмад настны арилжааны банкн дахь нэрийн дансанд шилжүүлнэ.”

2/8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг:

“8.5. Ахмад настны хүсэлтээр нэмэгдэл, хөнгөлөлтийг түүний хадгаламжийн дансанд шилжүүлж болно.”

2 дугаар зүйл. Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “Нийгмийн халамжийн үйлчилгээний” гэснийг “Энэ хуулийн 8.2-т заасан байгууллага болон холбогдох” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР